



9.

**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
БАЯНЖАРГАЛАН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2023 оны 02 сарын 10 өдөр

Дугаар 02

Аргатай

**ГХоршоог хөгжүүлэх сангийн 2023 оны тэргүүлэх  
чиглэл тогтоох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалаар батлагдсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.3.4, 3.4.6 дэх заалтуудыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын арван гуравдугаар хуралдаанаас **ТОГТООХ** нь :

1. Хоршоог хөгжүүлэх сангийн 2023 оны зээл олгох салбар, тэргүүлэх чиглэлийг хавсралтаар баталсугай.

2. Хоршоог хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны орлого зарлагыг нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийн дагуу мөрдүүлж, сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг Төсвийн тухай хуульд тогтоомжид заасан хугацаанд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг сумын засаг дарга (Т.Цэвэлмаа)-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (С.Баярхүү)-д үүрэг болгосугай.

ДАРГА  ДЭРДЭНЭБАТ



10.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн  
02 дугаар тогтоолын хавсралт

**БАЯНЖАРГАЛАН СУМЫН ХОРШООГ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН  
2023 ОНЫ ЗЭЭЛ ОЛГОХ САЛБАР, ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ**

№	Эдийн засгийн салбар	Чиглэл
1	Хүнсний салбар	<ul style="list-style-type: none"><li>- Сүү, сүүн бүтээгдэхүүн</li><li>- Талх нарийн боов, гурилан бүтээгдэхүүн</li><li>- Малын дайвар бүтээгдэхүүн боловсруулах худалдаалах</li><li>- Хоол үйлдвэрлэл</li><li>- Мах, махан бүтээгдэхүүн</li></ul>
2	Хөнгөн үйлдвэр	<ul style="list-style-type: none"><li>- Төмөр эдлэл үйлдвэрлэл</li><li>- Оёмол эсгүүр үйлдвэрлэл</li><li>- Гутал үйлдвэрлэл</li><li>- Модон эдлэл</li><li>- Сүлжмэл, нэхмэл ноос ноолууран эдлэл</li><li>- Хог хаягдал ангилан ялгалт дахин боловсруулах</li><li>- Ноос арьс шир боловсруулах</li></ul>
3	Газар тариалан	<ul style="list-style-type: none"><li>- Төмс хүнсний ногоо тариалах</li><li>- Мод жимсгэнэ тариалах</li><li>- Хүлэмжийн аж ахуй</li><li>- Тэжээлийн ургамал тариалах</li></ul>
4	Мал аж ахуй	<ul style="list-style-type: none"><li>- Арьс шир боловсруулах</li><li>- Эсгий эдлэл</li><li>- Мал үржлийн ажил үйлчилгээ</li><li>- Мал эмнэлгийн ажил үйлчилгээ</li><li>- Гахай шувууны туслах аж ахуй</li><li>- Мал нядалгааны цэг</li><li>- Махны чиглэлийн үхэр хонины аж ахуйг хөгжүүлэх</li></ul>
5	Барилга	<ul style="list-style-type: none"><li>- Блок, тоосго, замын өнгөт хавтан үйлдвэрлэл</li><li>- Зөөврийн сууц, төмөр хашаа хайс</li></ul>
6	Үйлчилгээ	<ul style="list-style-type: none"><li>- Үсчин гоо сайхан</li><li>- Авто засвар, дугуй засвар, гагнуур</li><li>- Гутал засварын үйлчилгээ</li><li>- Зочид буудлын үйлчилгээ</li><li>- Аялал жуулчлал</li></ul>